




**“БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ”
ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ДҮРЭМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар нь “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлагын баримт бичиг”, Нийслэлийн Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.8.1-д заасан Улаанбаатар хотын сүүний хэрэглээний 80 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангах зорилтыг хэрэгжүүлэх, нийслэлийн нутаг дэвсгэр дээр хөдөө аж ахуйн тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бэлчээр ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар мөн.

1.2. “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар нь Монгол Улсын Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төсвийн тухай, Усны тухай, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.

1.3. Энэхүү дүрмийн зорилго нь “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг тогтоох, удирдлага, зохион байгуулалтын бүтэц, хяналт, эрх үүргийг тодорхойлохтой холбоотой харилцааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохицуулахад оршино.

1.4. “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын өмчлөгч нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байх бөгөөд нийслэлийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэгч нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргаас олгогдсон эрх үүргийн дагуу Нийслэлийн Өмчийн харилцааны газар байна.

**Хоёр. “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” орон нутгийн өмчит төсөвт
үйлдвэрийн газрын оноосон нэр, оршин байгаа газар, тэмдэг**

2.1. Оноосон бүрэн нэр: “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар.

2.2. “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын оршин байгаа газар нь: Улаанбаатар хот. Сонгинохайрхан дүүрэг, 21 дугаар хороо, Өвөр шар хоолой.

2.3. “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар нь өөрийн бэлэгдэл /эмблем/-тэй байхаас гадна албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.

2.4. Тэмдгээр албан ёсны шийдвэр, албан бичиг, гэрээ хэлцлийг баталгаажуулна.

2.5. Тэмдгийг “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын даргаас итгэмжлэн хариуцуулсан ажилтан түшиж, ашиглалт хамгаалалт, хадгалалтыг хариуцна.

Гурав. “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын зорилго, үйл ажиллагааны чиглэл

3.1. “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үндсэн зорилго нь “Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих” хөтөлбөрийг хэрэгжүүлж, Австри улсын дэвшилтэт технологийн дагуу бэлчээрийн талбайн хөрсний бүтцийг алдагдуулахгүйгээр өөрийн орны хөрс, цаг уурын нөхцөлд тохируулан, байгаль орчинд ээлтэй, олон наст ногоон тэжээлийг тарималжуулан нутагшуулах замаар тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бэлчээр ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулахад оршино.

3.2. “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар нь дараах ажил үйлчилгээг эрхэлнэ. Үүнд:

3.2.1. Бэлчээрийн талбайг хагалахгүй, хөрсний унаган төрхийг алдагдуулахгүйгээр үрлэж тариалах Австри улсын дэвшилтэт шинэ технологийг туршиж, нэвтрүүлэх;

3.2.2. Дээрхи технологийн дагуу тариалсан олон найрлагат, уурагжуулсан витаминт тэжээлийг вакуумжуулан боох аргыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх;

3.2.3 Тэжээлийн ургамлын бүтэц, бүрдлийг нэмэгдүүлэх замаар нэгж талбайгаас авах хадлангийн гарцыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх;

3.2.4. Нэгж талбайгаас авах хадлангийн хэмжээ болон ногоон тэжээлийн чанарыг дээшлүүлснээр саалийн хугацаанд авах сүүний хэмжээг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх зэрэг болно.

3.2.5. Сургалтын төв, дадлагын талбай болон засварын төв бүхий “Эрчимжсэн мал аж ахуйн загвар аж ахуй” байгуулах;

3.2.6. Малчид, фермерүүдийн дундын хоршоо байгуулах замаар дээрхи дэвшилтэт технологийг малчид, фермерүүдийн талбай дээр нэвтрүүлэх;

Дөрөв. “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын эрх, үүрэг

4.1. “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар нь дор дурдсан эрх, үүрэгтэй байна. Үүнд:

4.1.1.Өөрт олгогдсон үл хөдлөх хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмшиж ашиглах;

4.1.2. Эргэлтийн бус хөрөнгийг өөрт олгосон эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулж, нийслэлийн Өмчийн харилцааны газрын шийдвэрийг үндэслэн олж авах, шилжүүлэх, данснаас хасах буюу устгах;

4.1.3. Зорилго, зорилтыг хэрэгжүүлэхтэй холбоотой үйлчилгээг иргэд аж ахуй нэгж байгууллагын хүсэлтийн дагуу гэрээ байгуулан гүйцэтгүүлэх ажлыг “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын даргын Нийслэлийн Засаг даргатай байгуулсан Контрактаар олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэх;

4.1.4. "Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих" хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын хэрэгцээг нарийвчилж тооцсон хөгжлийн үе шатны төлөвлөгөө боловсруулан, хөрөнгө оруулагчдад танилцуулж, шаардлагатай санхүүжилтийг бүрдүүлэхэд идэвхи санаачлагатай ажиллах

4.1.5. Хүний эрүүл мэнд, байгаль орчинд халгүй дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэн импортыг орлох, экспортын баримжаатай үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлийг баримтлах;

4.1.6. Гадаад, дотоодын холбогдох байгууллагуудтай зохих журмын дагуу харилцаа холбоо тогтоох;

4.1.7. Аж ахуйн нэгж, байгууллага иргэдээс тус газрын бүтээн байгуулалтанд зориулсан хандив тусламж, хөрөнгө оруулалтыг хүлээн авч, бүртгэлд бүртгэх.

Тав. "Бэлчээрийн менежмент төслийн нэгж" орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын удирдлага

5.1. "Бэлчээрийн менежмент төслийн нэгж" орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг дарга удирдана. Даргыг Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогчийн саналыг үндэслэн Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч томилж, чөлөөлнө.

5.2. "Бэлчээрийн менежмент төслийн нэгж" орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дарга нь "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-д заасан шалгуур хангасан байна.

5.3. Дарга нь төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах зөвлөлд орох, тэдгээрийн захиргаанд буюу олон нийтийн болон шашны байгууллага, сангийн удирдах ажлыг хавсран гүйцэтгэхийг хориглоно.

5.4. "Бэлчээрийн менежмент төслийн нэгж" орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг Нийслэлийн Засаг даргын захирамжаар батална.

5.5. "Бэлчээрийн менежмент төслийн нэгж" орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газарт Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор томилогдсон Удирдах Зөвлөл ажиллах ба Удирдах зөвлөл нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 54 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчийн хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн ажиллах журам"-ыг мөрдөн ажиллана.

5.6. Дарга нь дор дурдсан эрх үүрэгтэй байна. Үүнд:

5.6.1. Хууль тогтоомжийн хүрээнд "Бэлчээрийн менежмент төслийн нэгж" орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрэм, зорилтын санал, бизнес төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах;

5.6.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, удирдаж буй "Бэлчээрийн менежмент төслийн нэгж" орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын хэвийн үйл ажиллагааг хангасны үндсэн дээр санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг бүх талаар дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах;

5.6.3. "Бэлчээрийн менежмент төслийн нэгж" орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын эрх ашгийг дээдэлж, мэргэжил, ажлын дадлага туршлагаа бүрэн дайчлан ажиллах;

5.6.4. Ажил үүргээ гүйцэтгэх явцад олж авсан үйл ажиллагааны болон бизнесийн нууцыг хадгалах, хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх;

5.6.5. Батлагдсан удирдлагын бүтэц, зохион байгуулалт болон цалингийн сангийн хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, хөдөлмөрийн гэрээ болон бусад гэрээ байгуулан ажилтныг томилж, чөлөөлөх, шагнал урамшуулал олгох;

5.6.6. Байгууллагаа мэргэжлийн чадварлаг боловсон хүчнээр хангаж, тэднийг сургаж бэлтгэх, дадлагажуулах, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх замаар байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх;

5.6.7 Хүн амын аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэхүйц нөхцөл байдал үүссэн тохиолдолд мэргэжлийн байгууллагуудад хандаж, шаардлагатай гэж үзвэл үйл ажиллагааг зогсоох, хөл хорио тогтоох шийдвэр гаргуулах;

5.6.8. Дарга нь хууль тогтоомж, Контрактаар олгогдсон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, төлөөлөх;

5.6.9. Хууль тогтоомж болон гэрээгээр олгосон бусад эрх үүрэг;

5.7. Дарга нь эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргана.

5.8. Дарга нь өөрийн эрх, үүргийг нийслэлийн Засаг даргатай зөвшилцөж, итгэмжлэлийн үндсэн дээр холбогдох албан тушаалтанд түр шилжүүлж болно. Ийнхүү эрхээ итгэмжлэн шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

Зургаа. "Бэлчээрийн менежмент төслийн нэгж" орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын хяналт

6.1. "Бэлчээрийн менежмент төслийн нэгж" орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын үндсэн болон санхүүгийн үйл ажиллагааг хянах дотоод хяналттай байна. Дотоод хяналт шалгалтын ажиллах журмыг захирал батална.

6.2. Холбогдох хууль тогтоомж, журмын дагуу хүрээлэнгийн үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн аудитын дүгнэлт гаргуулна.

6.3. Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалт, ашиглалт болон санхүүгийн үйл ажиллагаанд Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс, нийслэлийн Өмчийн харилцааны газраас хяналт тавьж ажиллана.

6.4. Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт, шалгалтыг нягтлан бодогч хариуцан хэрэгжүүлнэ.

Долоо. "Бэлчээрийн менежмент төслийн нэгж" орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын санхүүжилт, санхүү бүртгэл, тайлан

7.1. "Бэлчээрийн менежмент төслийн нэгж" орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын үйл ажиллагааны зардлыг Нийслэлийн төсвөөс санхүүжүүлнэ.

7.2. "Бэлчээрийн менежмент төслийн нэгж" орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

тогтоомж, Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу жил бүр гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулна.

7.3. Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг захирал, нягтлан бодогч нар хариуцна.

7.4. Санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор гэрээний үндсэн дээр аудиторыг сонгон ажиллуулж болно.

7.5. Санхүүгийн тайланд дараах зүйлийг тусгана. Үүнд:

7.5.1. Баланс;

7.5.2. Үйл ажиллагааны үр дүнгийн тайлан;

7.5.3. Мөнгөн гүйлгээний тайлан;

7.5.4. Өмчийн өөрчлөлтийн тайлан;

7.5.5. Тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн хэлцлийн жагсаалт, нэр төрөл, үнийн дүн, удирдлагад олгосон цалин шагнал, урамшуулал;

7.5.6. Нэмэлт тайлбар;

7.5.7. Санхүүгийн тайлангийн тодруулга;

7.5.8. Хууль болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоосон бусад мэдээлэл.

7.6. Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тухайн жилийн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, зарцуулсан хөрөнгө санхүү, үр дүнгийн талаар тодорхой тусгасан тайланг хүргүүлнэ. Үүнд:

7.6.1. Тайлангийн хугацаанд эрхлэн явуулсан үндсэн үйл ажиллагааны талаарх танилцуулга, гарсан өөрчлөлтүүд болон эдгээр үйл ажиллагааны үр дүнгийн байдал, түүний өөрчлөлт;

7.6.2. Тайлангийн хугацаанд ажилчин, албан хаагчдад олгосон шагнал урамшуулал, удирдлагын зардлын хэмжээ;

7.6.3. Шаардлагатай бусад мэдээлэл, тайлбар.

7.7. Нийслэлийн Засаг даргатай байгуулсан Контрактын биелэлтийг хагас, бүтэн жилээр гаргаж, Удирдах зөвлөлөөрөө хэлэлцүүлэн, Нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газарт ирүүлнэ.

Найм. "Бэлчээрийн менежмент төслийн нэгж" орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын бичиг баримтыг хадгалах

8.1. "Бэлчээрийн менежмент төслийн нэгж" орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар нь дараах баримт бичгийг хадгална.

8.1.1 "Бэлчээрийн менежмент төслийн нэгж" орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрэм, дүрэмд орсон нэмэлт өөрчлөлт, газар байгуулах тухай холбогдох газруудын шийдвэр, тогтоол, улсын бүртгэлийн гэрчилгээ болон бусад гэрчилгээ сертификатууд;

8.1.2 Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангууд, түүнд хийгдсэн аудитын дүгнэлт, зөвлөмжүүд;

8.1.3. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримтууд түүнд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох бичиг баримтууд;

8.1.4. Үйлдвэрлэл, технологи, норм нормативууд түүнтэй холбогдох дүрэм, журам, зааврууд, холбогдох бусад баримт бичгүүд;

8.1.5. Хурлын тэмдэглэл, шийдвэр, захирлын тушаал, шийдвэрүүд;

8.1.6. Бусад ач холбогдол бүхий баримт бичгүүд.

8.2. Дээрх баримт бичгийг зохих журмын дагуу холбогдох ажилтан, албан хаагчаас хүлээн авч хадгалах, эрх бүхий этгээдэд захирлын шийдвэрээр танилцуулах, архивт шилжүүлэх ажлыг бичиг хэргийн ажилтан эрхлэн гүйцэтгэнэ.

Ес. “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрыг татан буулгах

9.1. “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрыг Иргэний хууль болон бусад хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу удирдах дээд байгууллага татан буулгана.

Арав. Хариуцлага

10.1. Монгол Улсын хууль тогтоомж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдийн тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамжийн биелэлтийг хэрэгжүүлэх явцад буруу шийдвэр гаргаж, бусдад хохирол учруулсан нь шүүхээр тогтоогдсон бол буруутай этгээдэд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

10.2. “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрыг оноосон нэр, бэлэгдэл /эмблем/-ийг зөвшөөрөлгүй ашигласан аж ахуйн нэгж, байгууллага иргэнд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Арван нэг. Бусад

11.1. Хуульд нийцүүлэн энэхүү дүрэмд тусгагдсанаас бусад асуудлыг хуулиар зохицуулна.

11.2. Энэ дүрэм нь Монгол улсын Бүртгэлийн ерөнхий газрын хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.